

## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СБА-2022/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: [gereltekhburtgelaudit03@gmail.com](mailto:gereltekhburtgelaudit03@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Төлбөрийн акт .....	19
4.2 Албан шаардлага .....	19
4.3 Зөвлөмж.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518398, Факс: 70518398  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.07.28 № 47  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН  
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН  
ДАРГА Д.ГАНТУЛГА ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>66,812,193.72</u></b>	<b><u>60,396,751.48</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>101,163.39</b>	<b>91,963.39</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	56,654.39	60,355.39
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>44,509.00</b>	<b>31,608.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	12,901.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	31,608.00	31,608.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>66,711,030.33</b>	<b>60,304,788.09</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>66,711,030.33</b>	<b>60,304,788.09</b>
35410	Бичиг хэргийн материал	1,860,600.00	857,650.00
35420	Аж ахуйн материал	10,511,388.00	3,970,308.00
35430	Сэлбэг хэрэгсэл	25,000.00	-
35450	Барилгын засварын материал	1,542,908.50	1,477,308.50
35460	Хүнсний материал	3,081,162.83	356,879.59
35470	Бусад хангамжийн материал	49,689,971.00	53,642,642.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>775,652,047.44</u></b>	<b><u>707,965,203.87</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>775,652,047.44</u></b>	<b><u>707,965,203.87</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>600,828,377.44</b>	<b>533,155,283.87</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	509,047,369.15	509,047,369.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(79,854,527.16)	(120,114,012.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,800,000.00	36,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,605,555.80)	(35,272,222.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	358,196,615.00	360,426,515.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(306,596,051.96)	(321,930,261.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	196,511,730.24	197,391,730.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	(143,619,658.65)	(153,962,616.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,332,640.00	14,332,640.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,838,073.38)	(5,917,943.41)
39217	Ном	51,453,890.00	52,354,086.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>174,823,670.00</b>	<b>174,809,920.00</b>
39301	Програм хангамж	20,731,475.00	20,731,475.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(20,717,725.00)	(20,731,475.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	174,809,920.00	174,809,920.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>842,464,241.16</u></b>	<b><u>768,361,955.35</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>163,500.00</u></b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>163,500.00</b>	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>163,500.00</b>	-
41361	Байгууллагад төлөх өглөг	161,500.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>842,300,741.16</u></b>	<b><u>768,361,955.35</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>842,300,741.16</b>	<b>768,361,955.35</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	964,719,547.09	964,719,547.09
51101	Өмч: - төрийн	964,719,547.09	964,719,547.09

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(186,067,328.24)</b>	<b>(260,006,114.05)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(186,067,328.24)	(186,067,328.24)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(73,938,785.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,648,522.31	63,648,522.31
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>842,464,241.16</u></b>	<b><u>768,361,955.35</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,205,792,900.00</b>	<b>1,160,992,274.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,197,500.00</b>	<b>4,747,874.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>9,494,500.00</b>	<b>4,747,874.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,494,500.00	4,747,874.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,604,000.00	3,378,678.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,890,500.00	1,369,196.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>10,703,000.00</b>	<b>-</b>
122001	Хандив тусламж /дотоод/	10,703,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,185,595,400.00</b>	<b>1,156,244,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,182,215,400.00</b>	<b>1,147,722,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,182,215,400.00	1,147,722,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,480,000.00</b>	<b>8,521,600.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,480,000.00	8,521,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>900,000.00</b>	<b>-</b>
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	900,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,257,581,517.15</b>	<b>1,234,931,059.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,257,581,517.15</b>	<b>1,234,931,059.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,106,937,009.60</b>	<b>1,188,792,271.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>674,594,557.87</b>	<b>723,949,737.57</b>
210101	Үндсэн цалин	433,583,159.00	449,674,865.74
210102	Нэмэгдэл	169,298,569.37	208,510,906.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,090,000.50	25,305,935.54
210104	Урамшуулал	45,622,829.00	40,458,029.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>82,877,235.70</b>	<b>93,349,296.91</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,657,498.70	82,447,038.61
210202	Тэтгэмжийн даатгал	6,804,935.00	3,158,783.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,443,947.00	2,217,907.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,360,986.00	502,324.36
210205	Эрүүл мэндийн даатгал	13,609,869.00	5,023,243.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>186,908,838.00</b>	<b>189,487,578.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,968,988.00	5,789,398.00
210302	Түлш, халаалт	168,920,290.00	169,626,640.00
210303	Цэвэр, бохир ус	12,019,560.00	14,071,540.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,734,562.75</b>	<b>20,208,935.00</b>

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,276,075.00	4,987,450.00
210402	Тээвэр, шатахуун	3,790,005.00	2,430,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,495,452.00	3,755,995.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,791,030.75	8,150,540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	382,000.00	884,950.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,478,561.75</b>	<b>31,983,109.64</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,064,688.00	
210502	Хоол, хүнс	14,413,873.75	26,273,109.64
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,710,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,114,675.00</b>	<b>23,339,270.00</b>
210604	Урсгал засвар	12,114,675.00	23,339,270.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>103,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	103,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,757,414.25</b>	<b>6,569,641.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,723,039.25	5,572,886.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	189,675.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,200.00	102,580.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	731,500.00	812,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>115,368,164.28</b>	<b>99,904,702.67</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,080,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,955,562.47	28,207,763.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,332,601.81	71,696,939.57
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>150,644,507.55</b>	<b>46,138,788.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>48,104,104.00</b>	<b>38,414,900.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,465,900.00	11,837,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,396,300.00	25,677,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,241,904.00	900,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>102,540,403.55</b>	<b>7,723,888.52</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,540,403.55	7,723,888.52
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(51,788,617.15)</b>	<b>(73,938,785.81)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(51,788,617.15)</b>	<b>(73,938,785.81)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	964,719,547.09	63,648,522.31	(134,278,711.09)	894,089,358.31

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>964,719,547.09</b>	<b>63,648,522.31</b>	<b>(134,278,711.09)</b>	<b>894,089,358.31</b>
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(51,788,617.15)	(51,788,617.15)
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>964,719,547.09</b>	<b>63,648,522.31</b>	<b>(186,067,328.24)</b>	<b>842,300,741.16</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>964,719,547.09</b>	<b>63,648,522.31</b>	<b>(186,067,328.24)</b>	<b>842,300,741.16</b>
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>964,719,547.09</b>	<b>63,648,522.31</b>	<b>(186,067,328.24)</b>	<b>842,300,741.16</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(73,938,785.81)	(73,938,785.81)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>964,719,547.09</b>	<b>63,648,522.31</b>	<b>(260,006,114.05)</b>	<b>768,361,955.35</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>1,189,199,400.00</b>	<b>1,158,803,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,604,000.00</b>	<b>2,559,500.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,604,000.00</b>	<b>2,559,500.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,604,000.00</b>	<b>2,559,500.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,604,000.00	2,559,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,185,595,400.00</b>	<b>1,156,244,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,182,215,400.00</b>	<b>1,147,722,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,182,215,400.00	1,147,722,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,480,000.00</b>	<b>8,521,600.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,480,000.00	8,521,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>900,000.00</b>	<b>-</b>
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	900,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,187,633,900.00</b>	<b>1,155,694,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,187,633,900.00</b>	<b>1,155,694,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,036,989,292.45</b>	<b>1,109,555,211.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>673,563,863.43</b>	<b>723,942,537.57</b>
210101	Үндсэн цалин	431,747,746.71	449,805,309.70
210102	Нэмэгдэл	174,992,547.15	208,373,262.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,892,700.50	25,305,935.54
210104	Үр дүнгийн урамшуулал	40,930,869.07	40,458,029.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83,021,624.72</b>	<b>93,349,296.91</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,657,498.70	82,447,038.61
210202	Тэтгэмжийн даатгал	6,804,935.00	3,158,783.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,443,947.00	2,217,907.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,360,986.00	502,324.36
210205	Эрүүл мэндийн даатгал	13,609,869.00	5,023,243.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>186,849,338.00</b>	<b>188,667,600.00</b>

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	5,968,988.00	5,789,398.00
210302	Түлш, халаалт	168,920,290.00	169,184,300.00
210303	Цэвэр, бохир ус	11,960,060.00	13,693,902.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,946,037.00</b>	<b>19,176,765.00</b>
210401	Бичиг хэрэг	2,081,475.00	1,757,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,720,000.00	2,430,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,495,452.00	3,755,995.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,270,210.00	7,134,370.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,378,900.00	4,099,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,923,982.00</b>	<b>24,943,468.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,064,888.00	189,160.00
210502	Хоол, хүнс	16,537,935.00	23,264,308.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,321,159.00	1,490,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,319,630.00</b>	<b>25,150,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,292,600.00	525,400.00
210604	Урсгал засвар	7,027,030.00	24,625,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>103,000.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	103,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,853,035.00</b>	<b>6,756,640.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,625,660.00	5,759,885.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	189,675.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,200.00	102,580.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	924,500.00	812,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>34,408,782.30</b>	<b>27,568,004.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,080,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,328,782.30	27,568,004.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>150,644,607.55</b>	<b>46,138,788.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>48,104,204.00</b>	<b>38,414,900.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,465,900.00	11,837,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,396,300.00	25,677,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,242,004.00	900,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>102,540,403.55</b>	<b>7,723,888.52</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,540,403.55	7,723,888.52
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,565,500.00</u></b>	<b><u>3,109,900.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,565,500.00</b>	<b>3,109,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,565,500.00</b>	<b>3,109,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,565,500.00</b>	<b>3,109,900.00</b>

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,565,500.00	3,109,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,565,500.00)</u></b>	<b><u>(3,109,900.00)</u></b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,158,722,800.00</b>	<b>1,150,282,300.00</b>	<b>8,440,500.00</b>	<b>99.27</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,158,722,800.00</b>	<b>1,150,282,300.00</b>	<b>8,440,500.00</b>	<b>99.27</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,120,205,000.00</b>	<b>1,104,209,111.48</b>	<b>15,995,888.52</b>	<b>98.57</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>726,582,600.00</b>	<b>723,942,537.57</b>	<b>2,640,062.43</b>	<b>99.64</b>
210101	Үндсэн цалин	452,125,900.00	449,805,309.70	<b>2,320,590.30</b>	99.49
210102	Нэмэгдэл	196,249,100.00	208,373,262.49	<b>(12,124,162.49)</b>	106.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,294,000.00	25,305,935.54	<b>4,988,064.46</b>	83.53
210104	Урамшуулал	47,913,600.00	40,458,029.84	<b>7,455,570.16</b>	<b>84.44</b>
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>98,088,700.00</b>	<b>93,349,296.91</b>	<b>4,739,403.09</b>	<b>95.17</b>
210201	Тэтгэврийн даатгал	69,025,300.00	82,447,038.61	<b>(13,421,738.61)</b>	119.44
210202	Тэтгэмжийн даатгал	7,265,800.00	3,158,783.52	<b>4,107,016.48</b>	43.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,812,700.00	2,217,907.23	<b>3,594,792.77</b>	38.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,453,200.00	502,324.36	<b>950,875.64</b>	34.57
210205	Эрүүл мэндийн даатгал	14,531,700.00	5,023,243.19	<b>9,508,456.81</b>	34.57
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>188,667,600.00</b>	<b>188,667,600.00</b>	-	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,765,000.00	5,789,398.00	<b>975,602.00</b>	<b>85.58</b>
210302	Түлш, халаалт	169,184,300.00	169,184,300.00	-	<b>100.00</b>
210303	Цэвэр, бохир ус	12,718,300.00	13,693,902.00	<b>(975,602.00)</b>	<b>107.67</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,092,800.00</b>	<b>19,856,765.00</b>	<b>4,236,035.00</b>	<b>82.42</b>
210401	Бичиг хэрэг	1,839,300.00	1,757,100.00	<b>82,200.00</b>	95.53
210402	Тээвэр, шатахуун	2,693,400.00	2,430,000.00	<b>263,400.00</b>	90.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,633,400.00	3,755,995.00	<b>1,877,405.00</b>	66.67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,147,400.00	7,134,370.00	<b>2,013,030.00</b>	77.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,779,300.00	4,779,300.00	-	100.00

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,625,300.00</b>	<b>24,943,468.00</b>	<b>3,681,832.00</b>	<b>87.14</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	190,800.00	189,160.00	1,640.00	99.14
210502	Хоол, хүнс	26,939,200.00	23,264,308.00	3,674,892.00	86.36
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,495,300.00	1,490,000.00	5,300.00	99.65
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,765,300.00</b>	<b>23,762,700.00</b>	<b>2,600.00</b>	<b>99.99</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,077,900.00	2,075,300.00	2,600.00	99.87
210604	Урсгал засвар	21,687,400.00	21,687,400.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>82,400.00</b>	<b>-</b>	<b>82,400.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	82,400.00	-	82,400.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,343,800.00</b>	<b>1,976,640.00</b>	<b>367,160.00</b>	<b>84.33</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,075,600.00	979,885.00	95,715.00	91.10
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	81,675.00	116,325.00	41.25
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,200.00	102,580.00	75,620.00	57.56
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	892,000.00	812,500.00	79,500.00	91.09
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,956,500.00</b>	<b>27,710,104.00</b>	<b>246,396.00</b>	<b>99.12</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,956,500.00	27,710,104.00	246,396.00	99.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,517,800.00</b>	<b>46,073,188.52</b>	<b>(7,555,388.52)</b>	<b>119.62</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38,517,800.00</b>	<b>38,414,900.00</b>	<b>102,900.00</b>	<b>99.73</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,837,900.00	11,837,900.00	-	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,679,500.00	25,677,000.00	2,500.00	99.99
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,400.00	900,000.00	100,400.00	89.96
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>7,658,288.52</b>	<b>(7,658,288.52)</b>	<b>-</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,658,288.52	(7,658,288.52)	-
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,158,722,800.00</b>	<b>1,150,282,300.00</b>		<b>99.27</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,147,722,800.00</b>	<b>1,147,722,800.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131001	Улсын төсвөөс санхүүжих	1,147,722,800.00	1,147,722,800.00	-	100.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>11,000,000.00</b>	<b>2,559,500.00</b>	<b>8,440,500.00</b>	<b>23.27</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,000,000.00	2,559,500.00	8,440,500.00	23.27
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>58</b>	<b>58</b>	<b>-</b>	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	56	56	-	
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Зөрүү		Хувь	
		Гүйцэтгэл			
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,521,600.00	(8,521,600.00)	-	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,521,600.00	(8,521,600.00)	-	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,456,000.00	(8,456,000.00)	-	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,456,000.00	(8,456,000.00)	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,938,100.00	(2,938,100.00)	-	
210604	Урсгал засвар	2,938,100.00	(2,938,100.00)	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,780,000.00	(4,780,000.00)	-	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,780,000.00	(4,780,000.00)	-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	737,900.00	(737,900.00)	-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	737,900.00	(737,900.00)	-	
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,600.00	(65,600.00)	-	
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	65,600.00	(65,600.00)	-	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,521,600.00	(8,521,600.00)	-	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,521,600.00	(8,521,600.00)	-	

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,521,600.00	(8,521,600.00)	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>51</b>	-	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	3	-	<b>100.00</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	30	-	<b>100.00</b>
620003	Үйлчлэх ажилтан	18	-	<b>100.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь Сургуулийн ногоон хөгжлийн бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлж, сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулагыг шинэчлэх, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох замаар мэргэжил эзэмшилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

**Алсын хараа:** Олон улсад өрсөлдөх чадвартай, үнэ цэнэтэй мэргэжилтэй ажилтан бэлтгэх

**Зорилт:** Сургуулийн ногоон хөгжлийн бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлж, сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох замаар мэргэжил эзэмшилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

- Иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх
- Мэргэжлийн ур чадвар олгох
- Дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 25,151.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14,467.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 24,698.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 19,758.9 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 453.0 мянган төгрөгөөр буурсан байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн тухай

хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

### Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	101.6	91.9	(9.7)
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	66,711.0	60,304.8	(6,406.2)
Үндсэн хөрөнгө	775,652.0	707,965.2	(67,686.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>842,464.2</b>	<b>768,361.9</b>	<b>(74,102.3)</b>
Өр төлбөр	163.5	0	(163.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>842,300.7</b>	<b>768,361.9</b>	<b>(73,938.8)</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>842,464.2</b>	<b>768,361.9</b>	<b>(74,102.3)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 60,304.8 мянган төгрөг болж, 6,406.2 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын зарцуулалт нэмэгдсэн нь нөлөөлжээ. Бараа материалын данс 85,017.9 мянган төгрөгийн худалдан авалтаар, дотооддоо тариалсан 469.0 мянган төгрөгийн хүнсний ногоог үнэ төлбөргүй орлогод авснаар нэмэгджээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 707,965.2 мянган төгрөг болж, 67,686.8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 3,109.9 мянган төгрөг, Хөдөлмөр нийгэм хамгааллын яамнаас хандиваар ирсэн 301 ширхэг номны үнэ нийт 900.2 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 44,800.6 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оны мөн үеэс 34,492.6 мянган төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 40,117.2 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,352,210.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,352,210.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 193,487.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,158,722.8 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,158,722.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,147,722.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 1,147,722.8 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 2,559.5 мянган төгрөгийн, нийт 1,150,282.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,142,624.0 мянган төгрөгийг зарцуулж, 7,658.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд сургалтын үйл ажиллагаагаар 8,521.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 8,456.0 мянган төгрөгийг зарцуулж, 65.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Бусад асуудлын хэсэг:**

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

## **3.8 Аудитын гол асуудал**

Нийт 24 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 16,404.1 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2021 онд нийт 1,506,339.8 мянган төгрөгийн 36 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,337,155.5 мянган төгрөгийн 23 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн цалинтай холбоотой 1,038.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож бүрэн биелүүлсэн, тээвэр шатахуунтай холбоотой 400.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,038.9	1	1,038.9	-	-	100.0
Албан шаардлага	1	400.0	1	400.0	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>1,438.9</b>	<b>2</b>	<b>1,438.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>100.0</b>

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18,333.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,929.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16,404.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж өгөв. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгөв.

##### 4.1 Төлбөрийн акт

Хөдөлмөрийн чадвар алдалтын акттай 2 ажилтны 1-12 сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй 1,929.4 мянган төгрөгийг цалингаас илүү суутгасан алдаа зөрчилтэй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

##### 4.2 Албан шаардлага

Байгууллага нь нийт 24 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 16,404.1 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 199 ширхэг 581,231.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. **Шилэн данстай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст нийт 1,506,339.8 мянган төгрөгийн 36 мэдээллийг ил тод байршуулахаас 1,337,155.5 мянган төгрөгийн 23 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

3. Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Цалинг буруу тооцоолон олгосон	1	1,929.4			1	1,929.4				
2	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	16,404.1					1	16,404.1		
3	Анхнэ өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		3	18,333.5	-	-	1	1,929.4	1	16,404.1	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
4	Шилэн дансны цахим хуудсанд ил тод мэдээлээгүй	1	1,337,155.5							1	1,337,155.5
Дүн		1	1,337,155.5	-	-	-	-	-	-	1	1,337,155.5
Нийт дүн		4	1,355,489.0	-	-	1	1,929.4	1	16,404.1	2	1,337,155.5